



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар Д/БЧБ

Арвайхээр сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Гёнсанбүг мужийн Гёнжү хотод 2023 оны 06 дугаар сарын 28-аас 06 дугаар сарын 30-ны хооронд зохион байгуулагдах Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбооны (NEAR) хуралд оролцох төлөөлөгчдийн замын зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 8,556,000 (найман сая таван зуун тавин зургаан мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансны 2022 оны үлдэгдлээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0670

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дүгээр
сарын 23-ны өдрийн 23/05 дугаар
захирамжийн хавсралт



Бүгд Найрамдах Солонгос Улсын Гёнсанбүг мужийн Гёнжүд болох
Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбооны (NEAR) хуралд оролцох
төлөөлөгчдийн зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ	Хугацаа (Хоногоор)	Нийт
1	Улаанбаатар-Инчон- Улаанбаатар чиглэлийн нислэгийн тийзийн үнэ	2,388,000x2хүн		4,776,000
2	Зам хоногийн болон хот доторх унааны зардал	60(\$) \times 2 хүн	4 хоног	1,680,000
3	Байрлал зардал (2023 оны 06 сарын 30, 07 сарын 1-ний өдөр)	150\$ \times 2хүн	2 хоног	2,100,000
Нийт				8,556,000

2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн ханшаар тооцов.
1 доллар =3500төгрөг